

АРД ДААТГАЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын огноо: 2024 оны 4 сарын 23-ны өдөр

Хурлын байршил: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Сентрал Тауэр, 17 давхар, Криптос хурлын танхим, ArdApp

Хурал эхэлсэн цаг: 10 цаг 00 минут

Хурлын дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Б. Золбоо

Хурлын ирц: Нийт саналын эрхтэй хувьцааны тоо 25,000,000 ширхэг, хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо 16,265,354 ширхэг буюу 65.06 хувь

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;
3. Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай;
4. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;

Тэмдэглэл:

ХЭХ-ын дарга, ТУЗ-ийн гишүүн Б.Золбоо: Хүрэлцэн ирсэн эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, харилцагч даатгуулагч та бүхний энэ өглөөний амгаланг айлтган мэндчилье. ТУЗ-ийн тогтоолын дагуу 2024 оны 4 сарын 23-ны өдрийн 10 цагаас Ард Даатгал ХК-ийн ХЭХ-ыг хуралдуулах зарыг хүргэсэн бөгөөд үүний дагуу өнөөдөр 10 цагаас хурлыг эхлүүлж нээж байна. Хурлын хүчин төгөлдөр болгох хурлын ирцийн мэдээллийг Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэлийг танилцуулахыг урьж байна.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл: Сайн байцгаана уу? Юуны өмнө Ард даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Өнөөдрийн хурлын дэгийн дагуу тооллогын комиссын бүрэлдэхүүнээс хурлын ирцийн баталгаажуулалтыг та бүхэнд танилцуулъя. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Компанийн нийт гаргасан 25,000,000 ширхэг энгийн хувьцаа байна. Үүнээс саналын эрхтэй 25,000,000 ширхэг энгийн хувьцаанаас **16,265,354** ширхэг буюу **65.06** хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байна.

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн тус хурал хүчин төгөлдөр болж байна. Баярлалаа.

Ард даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Тооллогын комисст баярлалаа. 65.06 ирцтэй хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр эхэлж байна. Хурлын дэгийг уншиж танилцуулъя.

Хурлын дэг:

★ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээх

10:00

- А Хурлын ирц танилцуулах
- А Хурлын хөтөлбөр, хэлэлцэх асуудал танилцуулах
- А Хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу танилцуулга хийх 10:20
 - А Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
 - А Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;
 - А Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай;
 - А ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
- А Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт 11:00
- А Санал авах 11:10
- А Санал хураалтын дүнг нэгтгэн, Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах 11:20
- А Хурлаас гарсан шийдвэрийг Хурлын дарга танилцуулж, Хурлыг хаах 11:30

Танилцуулсан:

Ард даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Ард Даатгал ХК-ийн хувьд 1994 оны 3 сарын 22-нд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө авснаар үйл ажиллагаа эхэлж байсан бөгөөд энэ онд 30 жилийн ойтой золгож байна. Ард Даатгал ХК-ийн ХЭХ-с төлөөлөл сонгон ТУЗ-ийг байгуулдаг бөгөөд ХЭХ-с сонгогдсон 9 гишүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөл ажилладаг. ТУЗ нь ердийн зургаан, хараат бус гурван гишүүнтэйгээр ажилладаг. Мөн Төлөөлөн удирдах зөвлөл маань 3 хороотой ажилладаг бөгөөд Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Аудитын хороо гэсэн 3 хороотой. Компани маань нийтдээ орон нутагт 21 салбартай үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд даатгалын үйлчилгээг цахимаар болон биетээр үзүүлэн ажиллаж байгаа бөгөөд Даатгалын газар, Эрсдэлийн удирдлагын газар, Санхүү удирдлага, үйл ажиллагааны газар гэсэн гурван газартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Сүүлийн дөрвөн жил Грант Торнтон Аудит компани манай санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийж дүгнэлт өгч ажиллаж байгаа бөгөөд Компанийн хувь Эерэг дүгнэлттэй ажиллаж байна.

Ард Даатгал ХК-ийн хувьцаа нь олон нийтэд нээлтэй арилжаалагдаж эхэлсэн цагаасаа МХБ-н ТОП 20 индекст жил бүр багтан арилжаалагдаж байна.

Өнгөрсөн онд ТУЗ-с ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бөгөөд харин хувьцаа эзэмшигчдэдээ хувь тэнцүүлсэн урамшуулал олгосон бөгөөд 1 ширхэг хувьцаанд 1 ширхэг АрдКойны урамшуулал олгосон байна.

ICT EXPO 23-т амжилттай оролцсон. Хувьцаа эзэмшигчдийн хуралаа амжилттай зохион байгуулсан. Мөн Хөрөнгө оруулалалч үндэстэн чуулганыг амжилттай зохион байгуулж оролцсон байна.

Олон улсын эрүүл мэндийн даатгалын хамтын ажиллагааг өргөжүүлэх санамж бичиг MSH China компанитай байгуулсан.

МҮХАҮТ-ын удирдах зөвлөлд Ард Даатгал ХК хоёр дахь удаагаа улиран сонгогдож ажиллахаар болсон байна.

2018 онд IPO хийснээс хойш 5 жилийн хугацаанд Ард Даатгал ХК 10 мянга орчим хувьцаа эзэмшигчтэй болж, 3.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг олгож, 120 сая АрдКойны урамшуулал олгож, 32.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр харилцагч нартаа олгосон байна.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаа АрдАпп-р хийх боломжтой болсон бөгөөд нөхөн төлбөрийн материалыг хүлээн авах процессыг цахимжуулан АрдАпп-д нэвтрүүлээ.

Санхүүгийн хувьд голлох үзүүлэлтийг дурдахад нийт хөрөнгө 44.2 тэрбум төгрөг болж өнгөрсөн жилийн мөн үеийн эцсээс 24 хувиар өссөн байна. Хувьцаа эзэмшигч та бүхний өөрийн хөрөнгө буюу эздийн өмч 18.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт хураамжийн орлого 45 хувиар өсч 32.4 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс цэвэр хураамжийн орлого 47 хувиар өсч 25.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт нөөц сан 22.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 52 хувиар өссөн. Цэвэр ашгийн хувь 3.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд нийт нөхөн маань 14.1 тэрбум төгрөг болж 79 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд гол нөлөөлсөн хүчин зүйлүүдийн хувьд сэлбэг хэрэгслийн үнийн өсөлт, эмнэлэг үйлчилгээ, эмийн үнийн өсөлт, хохирлын тоо нэмэгдсэн зэрэг нөлөөллүүд гарсан байна. Гэсэн хэдий ч бид хохирлын харьцааг 41.4 хувьд, зардлын харьцааг 55.6 хувьд барьж ажилласнаар хосолсон харьцаа 97.0 хувь гарч үндсэн үйл ажиллагаанаас тодорхой хэмжээний ашигтай ажилласан байна.

Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд ТОП 15 хувьцаа эзэмшигчид дунд манай компанийн 80 орчим хувь нь байршиж байдаг бөгөөд тус хувьцаа эзэмшигчдийн мэдээлэлд энд харагдаж байна. Хамгийн том хувьцаа эзэмшигч Ард санхүүгийн нэгдэл ХК нийт хувьцааны 45.5 хувийг эзэмшдэг байна. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр манай хувьцаа эзэмшигчдийн тоо 9,732 болсон байна. Хувьцааны арилжааны хувьд 2023 онд 1.9 сая ширхэг хувьцаа, нийт 1.6 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн бөгөөд дээд үнэ 950 төгрөг, доод үнэ 681 төгрөг хүрсэн бол жилийн арилжааны сүүлийн өдөр 874.5 төгрөгөөр хаагдсан байна. Ингэснээр 2023 оны жилийн эцсийн байдлаар компанийн үнэлгээ 21.9 тэрбум төгрөг болсон байна.

Манай санхүүгийн үйл ажиллагааны тайланд хөндлөнгийн аудитын дүгнэлт өгсөн Грант Торнтон Аудит ХХК-ийн партнёр Г.Саруулсайхан таныг урьж байна.

Грант Торнтон Аудит ХХК Г.Саруулсайхан: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Грант Торнтон Аудит ХХК-ийн аудитор, Ард даатгал ХК-ийн аудитын гэрээт ажлын багын ахлагч Г.Саруулсайхан байна. Манай Грант Торнтон Аудит бол дэлхийн топ 6 аудитын зөвлөх үйлчилгээний компанийн нэг бөгөөд Монгол улсад 2019 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд сүүлийн гурван жил Ард Даатгал ХК-д санхүүгийн тайланд аудит хийж ажиллаж байна. Ард Даатгал ХК нь даатгалын салбарт нилээд жин нөлөө дарахуйц компанийн нэг бөгөөд аудитын гэрээ байгуулснаас хойш аудитын төлөвлөгөө, хуваарь, завсар үеийн аудит, жилийн эцсийн аудитыг санхүүгийн тайлан гарснаас хойш хийж ажлын 43 өдөр 7 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж дүгнэлт гаргаж ажиллаа. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд дүгнэлтээ танилцуулсан бөгөөд өнөөдөр хувьцаа эзэмшигчид та бүхэнд танилцуулж байна. Аудитын багийн гишүүд тус слайдад харагдаж байна. Аудитын цар хүрээний хувьд аудитын үүрэг хариуцлага компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт үнэн зөв эсэх, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт зохих журмын дагуу хийгдсэн эсэх, зохицуулагч байгууллагаас тогтоосон бусад мэдээлэл үнэн зөв эсэх байдаг бол удирдлагын үүрэг хариуцлага СТОУС, холбогдох дүрэм, журмын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих бэлтгэх, тасралтгүй байх суурийг хэрэглэх байдаг.

Аудитын тайлангийн гол асуудалд “Ард даатгал” ХК нь санхүүгийн тайлангаа Сангийн Сайдын “Даатгалын компаниудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны

жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, аргачлал батлах тухай” 2020 оны 07 сарын 07-ны 132 дугаар тогтоолоор батлагдсан заавар, маягт, аргачлалын дагуу бэлтгэж, толилуулсан. Компани тайлант жилд удирдлагын шийдвэрээр өрийн үнэт цаасаарх ард койныг биет бус хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн бөгөөд холбогдох бодит үнэ цэнийн хэмжилтийг бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнасан. Зохистой харьцааны хувьд Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын харьцаа хоёр дугаар түвшин болох хангалттай түвшинд (2022: 118.65%) байгаа нь Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журмын 2.19-д заасан “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааг хангаж буй эсэхийг тодорхойлж, даатгагчийн төлбөрийн чадварын хоёрдугаар түвшин буюу даатгагчийн төлбөрийн чадвар хангалттай гэж үзнэ” гэснийг хангасан байна. Хараат бус аудиторын дүгнэлтийн хувьд бид Эерэг дүгнэлт өгсөн байна.

Ард даатгал ХК олон нийтийн компани, нөгөө талаасаа Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалттай этгээд гэдэг утгаараа Санхүүгийн зохицуулах хороо болон Сангийн яамнаас баталсан даатгалын багц дүрэм, нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журмын дагуу санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна гэж дүгнэлт өгсөн байгаа. Баярлалаа.

Ард даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Хурлын дэгийн дагуу дараагийн асуудлыг та бүхэнд танилцуулъя. Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг олгох тухай шийдвэрийг 2024 оны 2 сарын 8-ны өдөр ТУЗ-ийн ээлжит хурлаар хуралдан шийдвэрлэсэн. Тус шийдвэрээр 2023 оны цэвэр ашгаас нийт 750 сая төгрөгийн мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 30 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсний дагуу 2024 оны 4 сарын 30-ны өдрийн дотор олгохоор болсон байна. 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг та бүхэнд манай ХЭХ-ын дарга, ТУЗ-ийн гишүүн Б.Золбоо танилцуулна.

ХЭХ-ын дарга, ТУЗ-ийн гишүүн Б.Золбоо: 2023 оны хувьд даатгалын зах зээл үнийн өсөлт, байгаль орчны гэнэтийн гамшигт үзэгдлүүдтэй уялдан нөхөн төлбөрийн тоо, дүн өссөн хүндрэлтэй жил байсан хэдий ч Ард Даатгал ХК өөрсдийн нөөц боломжоо ашиглан хураамжийн орлогыг өнгөрсөн оны мөн үеэс 45 хувиар өсч, төсвөөс 30 хувиар давуулан нийт 32.4 тэрбум төгрөг хуримтлуулж, хосолсон харьцаа 97.0 хувьтай гарч, цэвэр ашиг 3.3 тэрбум төгрөгт хүрч ажилласан байна. Тайлант онд Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд зах зээлд тэргүүлэн ажилласан төдийгүй АрдАпп-д тус даатгалыг нэвтрүүлж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн, нөхөн төлбөрийн үйл ажиллагааг цахимжуулах зэрэг цоо шинэ боломжуудыг зах зээлд бий болгон ажиллаа.

ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлсэн ажлын үр дүн, бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлд сэтгэл хангалуун байгаа ба компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлд хангалттай гэсэн дүгнэлтийг өгч байна. ХЭХ-р тус дүгнэлтийг батлан шийдвэр гаргах тул та бүхэн саналаа идэвхтэй өгөхийг хүсье. Одоо та бүхэнд ТУЗ-н үйл ажиллагааны тайланг танилцуулъя.

Төлөөлөн удирдах зөвлөл өнгөрсөн хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга О.Одбаяр, ердийн гишүүнээр Г.Уянга, Б.Золбоо, Г.Цогбадрах, С.Оргил, Ч.Ганзориг нар ажилласан бол хараат бус гишүүдээр З.Ариун, Т.Билгээ, Б.Болорчимэг нар ажилласан бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Г.Баярбат нар ажиллаа. 2023 онд ТУЗ нь 5 удаа

ээлжит хурал, 2 удаа эчнээ санал хураалтаар хуралдан шийдвэрүүд гарган ажилласан бөгөөд нийт 25 шийдвэр гаргаж ажиллаа. ТУЗ-с гарсан онцлох шийдвэрүүдийг дурьдвал. Үүнд:

- ✓ Хувь тэнцүүлсэн урамшуулал олгох тухай
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай
- ✓ 2022 оны аудитлагдсан тайланг дүгнэж ТУЗ-ийн дүгнэлт гарган батлах тухай
- ✓ Гүйцэтгэх захирлын үнэлгээ батлах тухай
- ✓ ТУЗ-ийн дарга болон хороодыг томилох тухай
- ✓ Бизнес төлөвлөгөө 2023-2026 батлах тухай
- ✓ 2024 оны компанийн төсөв, төлөвлөгөө батлах тухай
- ✓ Хөрөнгө оруулалт, Давхар даатгалын төлөвлөгөө батлах тухай
- ✓ Компанийн засаглалын сайжруулах, КЗК-ыг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох журмуудыг шинээр болон шинэчлэн баталсан байна.

ТУЗ нь гурван хороонд хуваагдан ажиллаж байгаа бөгөөд Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүдээр Б.Болорчимэг, Ч.Ганзориг, З.Ариун, нарийн бичгийн даргаар нь Батцэнгэл нар ажиллаж байгаа ба 3 удаа хуралдаж 12 асуудал хэлэлцэн ажилласан байна. Санхүү, эрсдэл хөрөнгө оруулалтын хорооны гишүүд Б.Золбоо, С.Оргил, Г.Уянга, Т.Билгээ, З.Ариун, нарийн бичгийн даргаар Г.Баярбат нар ажиллаж байгаа бөгөөд 4 удаа хуралдаж 24 асуудал хэлэлцсэн байна. Аудитын хороо Г.Уянга, З.Ариун, Т.Билгээ, нарийн бичгийн даргаар П.Бямбасүрэн нар ажиллаж байгаа бөгөөд 4 удаа хуралдаж 16 асуудал хэлэлцсэн байна. Ард даатгал ХК-ийн удирдлагын баг бизнес төлөвлөгөө, стратеги төлөвлөгөө батлах, санхүүгийн тайлан хэлэлцүүлгийг батлах, аудитын дүгнэлтийг хянах зэрэг бүх үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөл амжилттай удирдан зохион байгуулсан гэдгийг нийт хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хэлмээр байна. Ард даатгал ХК дээр хувьцаа эзэмшигчдээ төлөөлөөд нэмж нэг зүйл хэлэхэд хараат бус гишүүд маань хараат бус үйл ажиллагаагаа маш сайн явуулдаг, компанийн засаглалын хувьд маш тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, тогтвортой өсөлтийг үйл ажиллагаандаа үзүүлж байгаа сайн засаглалтай компани гэдгийг хэлэхэд таатай байна.

Ард даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Хэлэлцсэн асуудлуудтай холбогдуулан асуух асуулт болон хэлэх санал байна уу?

Ирсэн асуултуудад хариулж, үйл ажиллагаатай холбоотой нэмэлт мэдээллүүд өгөв.

Ард даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: За санал хураалт дууссан байна. Одоо тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл санал хураалтын дүнг танилцуулна.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл: Та бүхэнд тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя.

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №24/02

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дахь хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хурлаар хэлэлцсэн Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 16,265,354 ширхэг буюу 65.06 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд Хурлаар 15,896,881 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:

1.1. Зөвшөөрсөн: 15,892,681 ширхэг буюу 97.709%

1.2. Татгалзсан: байхгүй.

1.3. Түдгэлзсэн: 4,200 ширхэг буюу 0.026% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай санал хураалтад санал өгсөн хувьцаа эзэмшигчдээс хүчингүй санал 3 байна.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулж дууслаа. Баярлалаа.

ХЭХ-ын дарга, ТУЗ-ийн гишүүн Б.Золбоо: Тооллогын комиссын бүрэлдэхүүнд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалт амжилттай явж дүнгээ танилцууллаа. За одоо хурлаас гарсан шийдвэрийг та бүхэнд танилцуулъя.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ №01/24

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 2024 оны 4 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №2 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

Ийнхүү хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр тогтоолыг баталсныг мэдэгдье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг баталснаар амжилттай өндөрлөлөө. Хурлаа амжилттай зохион байгуулсан Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн гишүүд, удирдлагын баг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн удирдлагын багт талархлаа илэрхийлье. Хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа. Хурлыг хаасныг албан ёсоор мэдэгдэж байна.

ХУРЛЫН ДАРГА



Б.ЗОЛБОО

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

A large, stylized handwritten signature in black ink, likely belonging to G. Bayarbat.

Г.БАЯРБАТ

**АРД ДААТГАЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Хурлын огноо: 2024 оны 4 сарын 23-ны өдөр

Хурлын байршил: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Сентрал Тауэр, 17 давхар, Криптос хурлын танхим, ArdApp

Хурал эхэлсэн цаг: 10 цаг 00 минут

Хурлын дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Б. Золбоо

Хурлын ирц: Нийт саналын эрхтэй хувьцааны тоо 25,000,000 ширхэг, хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо 16,265,354 ширхэг буюу 65.06 хувь

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;
3. Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай;
4. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;

Тэмдэглэл:

ХЭХ-ын дарга, ТУЗ-ийн гишүүн Б.Золбоо: Хүрэлцэн ирсэн эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, харилцагч даатгуулагч та бүхний энэ өглөөний амгаланг айлтган мэндчилье. ТУЗ-ийн тогтоолын дагуу 2024 оны 4 сарын 23-ны өдрийн 10 цагаас Ард Даатгал ХК-ийн ХЭХ-ыг хуралдуулах зарыг хүргэсэн бөгөөд үүний дагуу өнөөдөр 10 цагаас хурлыг эхлүүлж нээж байна. Хурлын хүчин төгөлдөр болгох хурлын ирцийн мэдээллийг Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэлийг танилцуулахыг урьж байна.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл: Сайн байцгаана уу? Юуны өмнө Ард даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Өнөөдрийн хурлын дэгийн дагуу тооллогын комиссын бүрэлдэхүүнээс хурлын ирцийн баталгаажуулалтыг та бүхэнд танилцуулъя. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Компанийн нийт гаргасан 25,000,000 ширхэг энгийн хувьцаа байна. Үүнээс саналын эрхтэй 25,000,000 ширхэг энгийн хувьцаанаас **16,265,354** ширхэг буюу **65.06** хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байна.

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн тус хурал хүчин төгөлдөр болж байна. Баярлалаа.

Ард даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Тооллогын комисст баярлалаа. 65.06 ирцтэй хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр эхэлж байна. Хурлын дэгийг уншиж танилцуулъя.

Хурлын дэг:

☆ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээх

10:00

- ☆ Хурлын ирц танилцуулах
- ☆ Хурлын хөтөлбөр, хэлэлцэх асуудал танилцуулах
- ☆ Хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу танилцуулга хийх 10:20
 - ☆ Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
 - ☆ Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;
 - ☆ Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай;
 - ☆ ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
- ☆ Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт 11:00
- ☆ Санал авах 11:10
- ☆ Санал хураалтын дүнг нэгтгэн, Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах 11:20
- ☆ Хурлаас гарсан шийдвэрийг Хурлын дарга танилцуулж, Хурлыг хаах 11:30

Танилцуулсан:

Ард даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Ард Даатгал ХК-ийн хувьд 1994 оны 3 сарын 22-нд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө авснаар үйл ажиллагаа эхэлж байсан бөгөөд энэ онд 30 жилийн ойтой золгож байна. Ард Даатгал ХК-ийн ХЭХ-с төлөөлөл сонгон ТУЗ-ийг байгуулдаг бөгөөд ХЭХ-с сонгогдсон 9 гишүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөл ажилладаг. ТУЗ нь ердийн зургаан, хараат бус гурван гишүүнтэйгээр ажилладаг. Мөн Төлөөлөн удирдах зөвлөл маань 3 хороотой ажилладаг бөгөөд Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Аудитын хороо гэсэн 3 хороотой. Компани маань нийтдээ орон нутагт 21 салбартай үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд даатгалын үйлчилгээг цахимаар болон биетээр үзүүлэн ажиллаж байгаа бөгөөд Даатгалын газар, Эрсдэлийн удирдлагын газар, Санхүү удирдлага, үйл ажиллагааны газар гэсэн гурван газартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Сүүлийн дөрвөн жил Грант Торнтон Аудит компани манай санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийж дүгнэлт өгч ажиллаж байгаа бөгөөд Компанийн хувь Эерэг дүгнэлттэй ажиллаж байна.

Ард Даатгал ХК-ийн хувьцаа нь олон нийтэд нээлтэй арилжаалагдаж эхэлсэн цагаасаа МХБ-н ТОП 20 индекст жил бүр багтан арилжаалагдаж байна.

Өнгөрсөн онд ТУЗ-с ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бөгөөд харин хувьцаа эзэмшигчдэдээ хувь тэнцүүлсэн урамшуулал олгосон бөгөөд 1 ширхэг хувьцаанд 1 ширхэг АрдКойны урамшуулал олгосон байна.

ICT EXPO 23-т амжилттай оролцсон. Хувьцаа эзэмшигчдийн хуралаа амжилттай зохион байгуулсан. Мөн Хөрөнгө оруулалагч үндэстэн чуулганыг амжилттай зохион байгуулж оролцсон байна.

Олон улсын эрүүл мэндийн даатгалын хамтын ажиллагааг өргөжүүлэх санамж бичиг MSH China компанитай байгуулсан.

МҮХАҮТ-ын удирдах зөвлөлд Ард Даатгал ХК хоёр дахь удаагаа улиран сонгогдож ажиллахаар болсон байна.

2018 онд IPO хийснээс хойш 5 жилийн хугацаанд Ард Даатгал ХК 10 мянга орчим хувьцаа эзэмшигчтэй болж, 3.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг олгож, 120 сая АрдКойны урамшуулал олгож, 32.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр харилцагч нартаа олгосон байна.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаа АрдАпп-р хийх боломжтой болсон бөгөөд нөхөн төлбөрийн материалыг хүлээн авах процессыг цахимжуулан АрдАпп-д нэвтрүүлээ.

Санхүүгийн хувьд голлох үзүүлэлтийг дурдахад нийт хөрөнгө 44.2 тэрбум төгрөг болж өнгөрсөн жилийн мөн үеийн эцсээс 24 хувиар өссөн байна. Хувьцаа эзэмшигч та бүхний өөрийн хөрөнгө буюу эздийн өмч 18.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт хураамжийн орлого 45 хувиар өсч 32.4 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс цэвэр хураамжийн орлого 47 хувиар өсч 25.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт нөөц сан 22.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 52 хувиар өссөн. Цэвэр ашгийн хувь 3.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд нийт нөхөн маань 14.1 тэрбум төгрөг болж 79 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд гол нөлөөлсөн хүчин зүйлүүдийн хувьд сэлбэг хэрэгслийн үнийн өсөлт, эмнэлэг үйлчилгээ, эмийн үнийн өсөлт, хохирлын тоо нэмэгдсэн зэрэг нөлөөллүүд гарсан байна. Гэсэн хэдий ч бид хохирлын харьцааг 41.4 хувьд, зардлын харьцааг 55.6 хувьд барьж ажилласнаар хосолсон харьцаа 97.0 хувь гарч үндсэн үйл ажиллагаанаас тодорхой хэмжээний ашигтай ажилласан байна.

Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд ТОП 15 хувьцаа эзэмшигчид дунд манай компанийн 80 орчим хувь нь байршиж байдаг бөгөөд тус хувьцаа эзэмшигчдийн мэдээлэлд энд харагдаж байна. Хамгийн том хувьцаа эзэмшигч Ард санхүүгийн нэгдэл ХК нийт хувьцааны 45.5 хувийг эзэмшдэг байна. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр манай хувьцаа эзэмшигчдийн тоо 9,732 болсон байна. Хувьцааны арилжааны хувьд 2023 онд 1.9 сая ширхэг хувьцаа, нийт 1.6 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн бөгөөд дээд үнэ 950 төгрөг, доод үнэ 681 төгрөг хүрсэн бол жилийн арилжааны сүүлийн өдөр 874.5 төгрөгөөр хаагдсан байна. Ингэснээр 2023 оны жилийн эцсийн байдлаар компанийн үнэлгээ 21.9 тэрбум төгрөг болсон байна.

Манай санхүүгийн үйл ажиллагааны тайланд хөндлөнгийн аудитын дүгнэлт өгсөн Грант Торнтон Аудит ХХК-ийн партнёр Г.Саруулсайхан таныг урьж байна.

Грант Торнтон Аудит ХХК Г.Саруулсайхан: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Грант Торнтон Аудит ХХК-ийн аудитор, Ард даатгал ХК-ийн аудитын гэрээт ажлын багын ахлагч Г.Саруулсайхан байна. Манай Грант Торнтон Аудит бол дэлхийн топ 6 аудитын зөвлөх үйлчилгээний компанийн нэг бөгөөд Монгол улсад 2019 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд сүүлийн гурван жил Ард Даатгал ХК-д санхүүгийн тайланд аудит хийж ажиллаж байна. Ард Даатгал ХК нь даатгалын салбарт нилээд жин нөлөө дарахуйц компанийн нэг бөгөөд аудитын гэрээ байгуулснаас хойш аудитын төлөвлөгөө, хуваарь, завсар үеийн аудит, жилийн эцсийн аудитыг санхүүгийн тайлан гарснаас хойш хийж ажлын 43 өдөр 7 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж дүгнэлт гаргаж ажиллаа. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд дүгнэлтээ танилцуулсан бөгөөд өнөөдөр хувьцаа эзэмшигчид та бүхэнд танилцуулж байна. Аудитын багийн гишүүд тус слайдад харагдаж байна. Аудитын цар хүрээний хувьд аудитын үүрэг хариуцлага компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт үнэн зөв эсэх, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт зохих журмын дагуу хийгдсэн эсэх, зохицуулагч байгууллагаас тогтоосон бусад мэдээлэл үнэн зөв эсэх байдаг бол удирдлагын үүрэг хариуцлага СТОУС, холбогдох дүрэм, журмын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих бэлтгэх, тасралтгүй байх суурийг хэрэглэх байдаг.

Аудитын тайлангийн гол асуудалд “Ард даатгал” ХК нь санхүүгийн тайлангаа Сангийн Сайдын “Даатгалын компаниудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны

жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, аргачлал батлах тухай” 2020 оны 07 сарын 07-ны 132 дугаар тогтоолоор батлагдсан заавар, маягт, аргачлалын дагуу бэлтгэж, толилуулсан. Компани тайлант жилд удирдлагын шийдвэрээр өрийн үнэт цаасаарх ард койныг биет бус хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн бөгөөд холбогдох бодит үнэ цэнийн хэмжилтийг бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнасан. Зохистой харьцааны хувьд Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын харьцаа хоёр дугаар түвшин болох хангалттай түвшинд (2022: 118.65%) байгаа нь Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журмын 2.19-д заасан “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааг хангаж буй эсэхийг тодорхойлж, даатгагчийн төлбөрийн чадварын хоёрдугаар түвшин буюу даатгагчийн төлбөрийн чадвар хангалттай гэж үзнэ” гэснийг хангасан байна. Хараат бус аудиторын дүгнэлтийн хувьд бид Эерэг дүгнэлт өгсөн байна.

Ард даатгал ХК олон нийтийн компани, нөгөө талаасаа Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалттай этгээд гэдэг утгаараа Санхүүгийн зохицуулах хороо болон Сангийн яамнаас баталсан даатгалын багц дүрэм, нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журмын дагуу санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна гэж дүгнэлт өгсөн байгаа. Баярлалаа.

Ард даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Хурлын дэгийн дагуу дараагийн асуудлыг та бүхэнд танилцуулъя. Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг олгох тухай шийдвэрийг 2024 оны 2 сарын 8-ны өдөр ТУЗ-ийн ээлжит хурлаар хуралдан шийдвэрлэсэн. Тус шийдвэрээр 2023 оны цэвэр ашгаас нийт 750 сая төгрөгийн мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 30 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсний дагуу 2024 оны 4 сарын 30-ны өдрийн дотор олгохоор болсон байна. 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг та бүхэнд манай ХЭХ-ын дарга, ТУЗ-ийн гишүүн Б.Золбоо танилцуулна.

ХЭХ-ын дарга, ТУЗ-ийн гишүүн Б.Золбоо: 2023 оны хувьд даатгалын зах зээл үнийн өсөлт, байгаль орчны гэнэтийн гамшигт үзэгдлүүдтэй уялдан нөхөн төлбөрийн тоо, дүн өссөн хүндрэлтэй жил байсан хэдий ч Ард Даатгал ХК өөрсдийн нөөц боломжоо ашиглан хураамжийн орлогыг өнгөрсөн оны мөн үеэс 45 хувиар өсч, төсвөөс 30 хувиар давуулан нийт 32.4 тэрбум төгрөг хуримтлуулж, хосолсон харьцаа 97.0 хувьтай гарч, цэвэр ашиг 3.3 тэрбум төгрөгт хүрч ажилласан байна. Тайлант онд Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд зах зээлд тэргүүлэн ажилласан төдийгүй АрдАпп-д тус даатгалыг нэвтрүүлж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн, нөхөн төлбөрийн үйл ажиллагааг цахимжуулах зэрэг цоо шинэ боломжуудыг зах зээлд бий болгон ажиллаа.

ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлсэн ажлын үр дүн, бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлд сэтгэл хангалуун байгаа ба компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлд хангалттай гэсэн дүгнэлтийг өгч байна. ХЭХ-р тус дүгнэлтийг батлан шийдвэр гаргах тул та бүхэн саналаа идэвхтэй өгөхийг хүсье. Одоо та бүхэнд ТУЗ-н үйл ажиллагааны тайланг танилцуулъя.

Төлөөлөн удирдах зөвлөл өнгөрсөн хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга О.Одбаяр, ердийн гишүүнээр Г.Уянга, Б.Золбоо, Г.Цогбадрах, С.Оргил, Ч.Ганзориг нар ажилласан бол хараат бус гишүүдээр З.Ариун, Т.Билгээ, Б.Болорчимэг нар ажилласан бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Г.Баярбат нар ажиллаа. 2023 онд ТУЗ нь 5 удаа

ээлжит хурал, 2 удаа эчнээ санал хураалтаар хуралдан шийдвэрүүд гарган ажилласан бөгөөд нийт 25 шийдвэр гаргаж ажиллаа. ТУЗ-с гарсан онцлох шийдвэрүүдийг дурьдвал. Үүнд:

- ✓ Хувь тэнцүүлсэн урамшуулал олгох тухай
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай
- ✓ 2022 оны аудитлагдсан тайланг дүгнэж ТУЗ-ийн дүгнэлт гарган батлах тухай
- ✓ Гүйцэтгэх захирлын үнэлгээ батлах тухай
- ✓ ТУЗ-ийн дарга болон хороодыг томилох тухай
- ✓ Бизнес төлөвлөгөө 2023-2026 батлах тухай
- ✓ 2024 оны компанийн төсөв, төлөвлөгөө батлах тухай
- ✓ Хөрөнгө оруулалт, Давхар даатгалын төлөвлөгөө батлах тухай
- ✓ Компанийн засаглалын сайжруулах, КЗК-ыг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох журмуудыг шинээр болон шинэчлэн баталсан байна.

ТУЗ нь гурван хороонд хуваагдан ажиллаж байгаа бөгөөд Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүдээр Б.Болорчимэг, Ч.Ганзориг, З.Ариун, нарийн бичгийн даргаар нь Батцэнгэл нар ажиллаж байгаа ба 3 удаа хуралдаж 12 асуудал хэлэлцэн ажилласан байна. Санхүү, эрсдэл хөрөнгө оруулалтын хорооны гишүүд Б.Золбоо, С.Оргил, Г.Уянга, Т.Билгээ, З.Ариун, нарийн бичгийн даргаар Г.Баярбат нар ажиллаж байгаа бөгөөд 4 удаа хуралдаж 24 асуудал хэлэлцсэн байна. Аудитын хороо Г.Уянга, З.Ариун, Т.Билгээ, нарийн бичгийн даргаар П.Бямбасүрэн нар ажиллаж байгаа бөгөөд 4 удаа хуралдаж 16 асуудал хэлэлцсэн байна. Ард даатгал ХК-ийн удирдлагын баг бизнес төлөвлөгөө, стратеги төлөвлөгөө батлах, санхүүгийн тайлан хэлэлцүүлгийг батлах, аудитын дүгнэлтийг хянах зэрэг бүх үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөл амжилттай удирдан зохион байгуулсан гэдгийг нийт хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хэлмээр байна. Ард даатгал ХК дээр хувьцаа эзэмшигчдээ төлөөлөөд нэмж нэг зүйл хэлэхэд хараат бус гишүүд маань хараат бус үйл ажиллагаагаа маш сайн явуулдаг, компанийн засаглалын хувьд маш тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, тогтвортой өсөлтийг үйл ажиллагаандаа үзүүлж байгаа сайн засаглалтай компани гэдгийг хэлэхэд таатай байна.

Ард даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Хэлэлцсэн асуудлуудтай холбогдуулан асуух асуулт болон хэлэх санал байна уу?

Ирсэн асуултуудад хариулж, үйл ажиллагаатай холбоотой нэмэлт мэдээллүүд өгөв.

Ард даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: За санал хураалт дууссан байна. Одоо тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл санал хураалтын дүнг танилцуулна.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл: Та бүхэнд тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя.

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №24/02

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дахь хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хурлаар хэлэлцсэн Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 16,265,354 ширхэг буюу 65.06 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд Хурлаар 15,896,881 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:

1.1. Зөвшөөрсөн: 15,892,681 ширхэг буюу 97.709%

1.2. Татгалзсан: байхгүй.

1.3. Түдгэлзсэн: 4,200 ширхэг буюу 0.026% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай санал хураалтад санал өгсөн хувьцаа эзэмшигчдээс хүчингүй санал 3 байна.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулж дууслаа. Баярлалаа.

ХЭХ-ын дарга, ТУЗ-ийн гишүүн Б.Золбоо: Тооллогын комиссын бүрэлдэхүүнд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалт амжилттай явж дүнгээ танилцууллаа. За одоо хурлаас гарсан шийдвэрийг та бүхэнд танилцуулъя.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ №01/24

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 2024 оны 4 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №2 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

Ийнхүү хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр тогтоолыг баталсныг мэдэгдье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг баталснаар амжилттай өндөрлөлөө. Хурлаа амжилттай зохион байгуулсан Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн гишүүд, удирдлагын баг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн удирдлагын багт талархлаа илэрхийлье. Хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа. Хурлыг хаасныг албан ёсоор мэдэгдэж байна.

ХУРЛЫН ДАРГА



Б.ЗОЛБОО

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.БАЯРБАТ